



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А04

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд Цус сэлбэлт судлалын үндэсний төвд Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Үнэлгээний хорооны дарга: - Ч.Батболд /Захиргаа, маркетингийн албаны дарга/

Гишүүд: - Б.Өнөрцэцэг /Үйлдвэрлэлийн тасгийн Технологич сувилагч/

-Ю.Энхжаргал /Хөндлөнгийн гишүүн, Хүний хөгжлийн сургалтын төвийн менежер/ тохиролцсоноор

-Б.Банзрагч /Хөндлөнгийн гишүүн, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш/ тохиролцсоноор

Нарийн бичгийн дарга: -Б.Билгүүн / Захиргаа, маркетингийн албаны Дотоод аудитор/

2. Худалдан авах үйл ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга /Ч.Батболд/, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг чанд

мөрдөн, авлига, ашиг сонирхолын зөрчлөөс ангид ажиллахыг Үнэлгээний хорооны гишүүдэд үүрэг болгож, зөвлөсүгэй.

3. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орж ажилласан хөндлөнгийн гишүүдэд зохих журмын дагуу урамшуулал тооцож, Худалдан авах ажиллагааны орлогоос олгохыг Санхүү, бүртгэлийн албаны дарга /Б.Өнөрзул/-д зөвшөөрсүгэй.

4. Сонгон шалгаруулалттай холбоотой мэдэгдэл, тайлбар гаргаж, Хувийн ашиг сохирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг хүлээн авч бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан /Я.Тогтохням/-д өгөхийг Үнэлгээний хорооны гишүүдэд даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР